



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
http://www.parliament.mn

2025.11.17 № 49

ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД
Э.БАТ-АМГАЛАН ТАНАА

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг орон
сууцжуулах талаар

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай НҮБ-ын Конвенцын 9-р зүйл. Хүртээмж; Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйл.Орон сууц, дэд бүтцийн байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй хүний хэрэгцээ, шаардлагад нийцүүлэхээр заасныг хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар;

2.Танай яамнаас хэрэгжүүлж байгаа орон сууцжуулалт болон түүнтэй холбоотой төсөл, хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хэрхэн хамруулж байгаа болон хөнгөлөлттэй орон сууцны хөтөлбөрт хамруулах, орон сууцжуулах талаар баримталж байгаа бодлого, арга хэмжээ;

3.Сүүлийн гурван жилд орон сууцжуулах хөтөлбөрт хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хэрхэн хамруулсан талаарх тоон мэдээлэл, тайланг ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



О.САРАНЧУЛУУН

2025000076